



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2024/138/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Архангай аймаг  
2024 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа  
Утас: 7033-3141

Цахим хаяг: [Baigalmaat@audit.gov.mn](mailto:Baigalmaat@audit.gov.mn)

Аудитын менежер Д.Нэргүйбаатар  
Утас: 7033-2860

Цахим хаяг: [Nerguibaatar@audit.gov.mn](mailto:Nerguibaatar@audit.gov.mn)

Аудитор Л.Соёлмөнх  
Утас: 7033-3019

Цахим хаяг: [Soyolmunkhl@audit.gov.mn](mailto:Soyolmunkhl@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АРХАНГАЙ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.02.06

№

04

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Цалингийн сангаас албан хаагчдад 16,018.9 мянган төгрөгийн шагнал урамшуулал олгож төсвийг зориулалт бус зарцуулсан, 4,010.3 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг илүү тооцож олгосон.
2. Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 7,722.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэлгүй их хэмжээгээр бараа материал бэлтгэсэн.
3. Засаг даргын нөөц хөрөнгө болон бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлаас төсөвт зохицуулалт хийлгүйгээр 17,860.2 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, зардлыг зориулалт бусаар зарцуулсан.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хууль болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалыг зөрчсөн бөгөөд аудитын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

## Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Архангай аймгийн түүхт 100 жилийн ой тохиож байгаатай холбоотойгоор хөрөнгийн зардал өмнөх оноос 904,166.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн батлагдсан байна.

## Аудитын гол асуудал

Монгол улсын Засгийн газрын 2022 оны 107, 489, 491 дүгээр тогтоол, 2023 оны 241 дүгээр тогтоол, Архангай аймгийн Засаг даргын А/74 дүгээр захирамжийн дагуу төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотой цалингийн сан нэмэгдсэн байна.

## Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2023 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 үндсэн зорилтын хүрээнд 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг сумын Засаг даргаас **84.0** хувиар үнэлжээ.

*Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.*

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>26,118,849.00</b>	<b>78,523,674.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>12,033,849.00</b>	<b>38,212,709.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>12,033,849.00</b>	<b>38,212,709.00</b>
35410	Бичиг хэргийн материал	2,261,900.00	4,264,570.00
35420	Аж ахуйн материал	3,750,279.00	13,010,779.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	7,088,000.00
35450	Барилгын засварын материал	871,670.00	399,360.00
35470	Бусад хангамжийн материал	5,150,000.00	13,450,000.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	<b>14,085,000.00</b>	<b>40,310,965.00</b>
36100	Барааны нөөц	630,000.00	630,000.00
36300	Тэжээлийн нөөц	13,455,000.00	39,680,965.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>771,594,993.59</b>	<b>1,429,874,102.94</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>771,594,993.59</b>	<b>1,429,874,102.94</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>724,883,993.59</b>	<b>1,383,410,602.94</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	399,008,681.88	729,882,781.88
39202	Хуримтлагдсан элэгдэл	-57,061,281.56	-69,909,366.74
39203	Авто-тээврийн хэрэгсэл	110,694,800.00	110,694,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-73,368,377.59	-83,651,353.87
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	100,656,879.60	110,217,079.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	-72,948,091.48	-93,157,660.52
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	69,344,092.68	72,787,092.68
39208	Хуримтлагдсан элэгдэл	-41,992,088.57	-49,831,389.40
39214	Бусад үндсэн хөрөнгө	647,155,472.52	647,155,472.52
39215	Хуримтлагдсан элэгдэл	-356,606,093.89	-411,467,395.21
39216	Дуусаагүй барилга, байгууламж	0.00	420,690,542.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>46,711,000.00</b>	<b>46,463,500.00</b>
39301	Программ хангамж	1,237,500.00	1,237,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-742,500.00	-990,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	46,216,000.00	46,216,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>797,713,842.59</b>	<b>1,508,397,776.94</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>797,713,842.59</b>	<b>1,508,397,776.94</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>797,713,842.59</b>	<b>1,508,397,776.94</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	465,703,585.08	465,703,585.08
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	465,703,585.08	465,703,585.08
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>330,445,687.51</b>	<b>1,041,129,621.86</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	445,760,824.09	330,445,687.51
51220	Тайлант үеийн үр дүн	-115,315,136.58	710,683,934.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,564,570.00	1,564,570.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>797,713,842.59</b>	<b>1,508,397,776.94</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>904,035,850.21</b>	<b>3,293,467,234.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>144,430,800.21</b>	<b>751,108,192.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>144,430,800.21</b>	<b>751,108,192.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>130,975,800.21</b>	<b>28,851,250.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	130,975,800.21	28,851,250.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	665,576,542.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	13,455,000.00	56,680,400.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>759,605,050.00</b>	<b>2,542,359,042.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>8,981,850.00</b>	<b>52,952,142.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,604,800.00	9,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,377,050.00	43,952,142.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>750,623,200.00</b>	<b>2,489,406,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	750,623,200.00	2,489,406,900.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,012,800,302.01</b>	<b>1,799,538,345.65</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,012,800,302.01</b>	<b>1,799,538,345.65</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>953,058,540.82</b>	<b>1,520,170,252.13</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>497,199,371.68</b>	<b>880,186,752.13</b>
210101	Үндсэн цалин	390,266,464.29	488,569,617.43
210102	Нэмэгдэл	54,239,648.00	243,555,647.68
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,494,730.30	72,625,853.34
210104	Урамшуулал	16,198,529.09	75,435,633.68
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>62,265,815.34</b>	<b>111,139,308.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	41,955,820.27	76,806,510.53
210202	Тэтгэмжийн даатгал	5,044,217.76	8,792,496.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,076,640.30	7,003,059.22
210204	Ажилгүйдлийн даатгал	1,015,012.45	1,682,365.05
210205	Эрүүл мэндийн даатгал	10,174,124.56	16,854,876.48
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>70,667,719.00</b>	<b>83,002,672.33</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,605,236.00	8,382,144.33
210302	Түлш, халаалт	58,154,962.00	66,545,659.00
210303	Цэвэр, бохир ус	5,907,521.00	8,074,869.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>28,498,948.00</b>	<b>30,871,230.02</b>
210401	Бичиг хэрэг	9,353,200.00	13,229,600.00
210402	Тээвэр, шатахуун	7,998,950.00	9,999,923.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,991,298.00	4,641,707.02
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,975,500.00	3,000,000.00
210408	Бараа материал акталсны зардал	6,180,000.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,547,614.00</b>	<b>10,588,990.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	450,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	210,000.00

210604	Урсгал засвар	7,547,614.00	9,928,990.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>0.00</b>	<b>3,985,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	0.00	3,985,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>139,261,235.00</b>	<b>61,918,389.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	136,969,427.00	58,131,642.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	306,852.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	336,566.00	281,972.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	148,390.00	55,000.00
210807	Газрын төлбөр	0.00	2,949,775.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>147,617,837.80</b>	<b>338,477,910.65</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,223,500.00	225,499,178.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,299,500.00	6,690,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	106,094,837.80	106,288,732.65
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>59,741,761.19</b>	<b>279,368,093.52</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>35,743,234.00</b>	<b>81,123,500.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,866,184.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10,191,000.00	51,147,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,686,050.00	29,975,900.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>23,998,527.19</b>	<b>198,244,593.52</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,998,527.19	198,244,593.52
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-108,764,451.80</b>	<b>1,493,928,888.35</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>6,550,684.78</b>	<b>783,244,954.00</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	6,550,684.78	0.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	0.00	783,244,954.00
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-115,315,136.58</b>	<b>710,683,934.35</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>890,580,850.21</b>	<b>2,571,210,292.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>130,975,800.21</b>	<b>28,851,250.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>130,975,800.21</b>	<b>28,851,250.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>130,975,800.21</b>	<b>28,851,250.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	130,975,800.21	28,851,250.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>759,605,050.00</b>	<b>2,542,359,042.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>8,981,850.00</b>	<b>52,952,142.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,604,800.00	9,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,377,050.00	43,952,142.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>750,623,200.00</b>	<b>2,489,406,900.00</b>

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	750,623,200.00	2,489,406,900.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>890,580,850.21</b>	<b>1,688,974,038.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>890,580,850.21</b>	<b>1,688,974,038.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>830,839,089.02</b>	<b>1,409,605,944.48</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>497,199,371.68</b>	<b>880,186,752.13</b>
210101	Үндсэн цалин	390,266,464.29	488,569,617.43
210102	Нэмэгдэл	54,239,648.00	243,555,647.68
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,494,730.30	72,625,853.34
210104	Урамшуулал	16,198,529.09	75,435,633.68
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>62,265,815.34</b>	<b>111,139,308.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	41,955,820.27	76,806,510.53
210202	Тэтгэмжийн даатгал	5,044,217.76	8,792,496.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,076,640.30	7,003,059.22
210204	Ажилгүйдлийн даатгал	1,015,012.45	1,682,365.05
210205	Эрүүл мэндийн даатгал	10,174,124.56	16,854,876.48
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>64,817,719.00</b>	<b>90,090,672.33</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,605,236.00	8,382,144.33
210302	Түлш, халаалт	52,304,962.00	73,633,659.00
210303	Цэвэр, бохир ус	5,907,521.00	8,074,869.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>20,949,448.00</b>	<b>29,506,860.02</b>
210401	Бичиг хэрэг	7,983,700.00	11,929,070.00
210402	Тээвэр, шатахуун	7,998,950.00	9,999,923.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,991,298.00	4,641,707.02
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,975,500.00	2,936,160.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,947,500.00</b>	<b>13,077,520.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	2,705,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	915,840.00
210604	Урсгал засвар	7,947,500.00	9,456,680.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>0.00</b>	<b>3,985,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	0.00	3,985,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>139,261,235.00</b>	<b>63,278,389.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	136,969,427.00	59,491,642.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	306,852.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	336,566.00	281,972.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	148,390.00	55,000.00
210807	Газрын төлбөр	0.00	2,949,775.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>38,398,000.00</b>	<b>218,341,443.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,098,500.00	210,289,743.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,299,500.00	8,051,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>59,741,761.19</b>	<b>279,368,093.52</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>35,743,234.00</b>	<b>81,123,500.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,866,184.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10,191,000.00	51,147,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,686,050.00	29,975,900.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>23,998,527.19</b>	<b>198,244,593.52</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,998,527.19	198,244,593.52

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	882,236,254.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	882,236,254.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	882,236,254.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	882,236,254.00
223001	Бусад хөрөнгө	0.00	783,244,954.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	98,991,300.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	-882,236,254.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	465,703,585.08	1,564,570.00	445,760,824.09	913,028,979.17
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	465,703,585.08	1,564,570.00	445,760,824.09	913,028,979.17
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-115,315,136.58	-115,315,136.58
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	465,703,585.08	1,564,570.00	330,445,687.51	797,713,842.59
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	465,703,585.08	1,564,570.00	330,445,687.51	797,713,842.59
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	465,703,585.08	1,564,570.00	330,445,687.51	797,713,842.59
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	710,683,934.35	710,683,934.35
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	465,703,585.08	1,564,570.00	1,041,129,621.86	1,508,397,776.94

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,521,031,200.00	2,320,013,556.48	201,017,643.52	92.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,574,492,100.00	1,450,780,502.48	123,711,597.52	92.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,493,344,500.00	1,369,657,002.48	123,687,497.52	91.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	963,257,200.00	880,186,752.13	83,070,447.87	91.38
210101	Үндсэн цалин	538,520,300.00	488,569,617.43	49,950,682.57	90.72
210102	Нэмэгдэл	268,121,900.00	243,555,647.68	24,566,252.32	90.84

210103	Унаа хоолны хөнгөлөлт	99,300,000.00	72,625,853.34	26,674,146.66	73.14
210104	Урамшуулал	57,315,000.00	75,435,633.68	-18,120,633.68	131.62
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>120,407,200.00</b>	<b>111,139,308.00</b>	<b>9,267,892.00</b>	<b>92.30</b>
210201	Тэтгэврийн даатгал	81,876,900.00	76,806,510.53	5,070,389.47	93.81
210202	Тэтгэмжийн даатгал	9,632,600.00	8,792,496.72	840,103.28	91.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,706,100.00	7,003,059.22	703,040.78	90.88
210204	Ажилгүйдлийн даатгал	1,926,500.00	1,682,365.05	244,134.95	87.33
210205	Эрүүл мэндийн даатгал	19,265,100.00	16,854,876.48	2,410,223.52	87.49
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>100,500,000.00</b>	<b>90,090,672.33</b>	<b>10,409,327.67</b>	<b>89.64</b>
210301	Гэрэл, цахилгаан	12,000,000.00	8,382,144.33	3,617,855.67	69.85
210302	Түлш, халаалт	79,000,000.00	73,633,659.00	5,366,341.00	93.21
210303	Цэвэр, бохир ус	9,500,000.00	8,074,869.00	1,425,131.00	85.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>30,000,000.00</b>	<b>29,570,700.02</b>	<b>429,299.98</b>	<b>98.57</b>
210401	Бичиг хэрэг	12,000,000.00	11,929,070.00	70,930.00	99.41
210402	Тээвэр, шатахуун	10,000,000.00	9,999,923.00	77.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,000,000.00	4,641,707.02	358,292.98	92.83
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000.00	3,000,000.00	0.00	100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>17,000,000.00</b>	<b>16,456,680.00</b>	<b>543,320.00</b>	<b>96.80</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	9,456,680.00	543,320.00	94.57
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,000,000.00</b>	<b>3,985,000.00</b>	<b>1,015,000.00</b>	<b>79.70</b>
210702	Дотоод албан томилолт	5,000,000.00	3,985,000.00	1,015,000.00	79.70
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>19,779,200.00</b>	<b>19,338,147.00</b>	<b>441,053.00</b>	<b>97.77</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,629,200.00	15,551,400.00	77,800.00	99.50
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	500,000.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	350,000.00	281,972.00	68,028.00	80.56
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	300,000.00	55,000.00	245,000.00	18.33
210807	Газрын төлбөр	3,000,000.00	2,949,775.00	50,225.00	98.33
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>237,400,900.00</b>	<b>218,889,743.00</b>	<b>18,511,157.00</b>	<b>92.20</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	229,300,900.00	210,789,743.00	18,511,157.00	91.93
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,100,000.00	8,100,000.00	0.00	100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>81,147,600.00</b>	<b>81,123,500.00</b>	<b>24,100.00</b>	<b>99.97</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>81,147,600.00</b>	<b>81,123,500.00</b>	<b>24,100.00</b>	<b>99.97</b>

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	51,147,600.00	51,147,600.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,000,000.00	29,975,900.00	24,100.00	99.92
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>946,539,100.00</b>	<b>869,233,054.00</b>	<b>77,306,046.00</b>	<b>91.83</b>
223001	Бусад хөрөнгө	946,539,100.00	869,233,054.00	77,306,046.00	91.83
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,521,031,200.00</b>	<b>2,320,013,556.48</b>	<b>201,017,643.52</b>	<b>92.03</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,382,186,900.00</b>	<b>2,291,162,306.48</b>	<b>91,024,593.52</b>	<b>96.18</b>
320001	Орон нутгийн төсвөөс	2,382,186,900.00	2,291,162,306.48	91,024,593.52	96.18
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>138,844,300.00</b>	<b>28,851,250.00</b>	<b>109,993,050.00</b>	<b>20.78</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	28,844,300.00	28,851,250.00	-6,950.00	100.02
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	110,000,000.00	0.00	110,000,000.00	0.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>52.00</b>	<b>52.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
620001	Удирдах ажилтан	4.00	4.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	9.00	9.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	21.00	21.00	0.00	100.00
620004	Гэрээт ажилтан	18.00	18.00	0.00	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	52,852,142.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	52,852,142.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	52,852,142.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	52,852,142.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	52,852,142.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	52,852,142.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	52,852,142.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсөв захирагчид хуваарилсан хөрөнгө	43,952,142.00

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **1,256,971.5** мянган төгрөгийн 4 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад бүрэн залрууллаа.

Залруулсан алдаа:

- ✓ Тээвэр шатахуунд 30,900.6 мянган төгрөг зарцуулсныг анхан шатны баримтаар тулган шалгахад хэдэн литр ямар хэмжээний шатах тослох материал худалдан авсан нь тодорхойгүй, “бөөн” дүнгээр орлогод авч, зарлагадсан нь УСНББОУС 1, 12, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.4.1, 13.1 дэх заалт болон аудитын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул бараа материалын тайланд залруулга хийлгэлээ.
- ✓ Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас 31,606.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авсныг бараа материалын дансаар дамжуулж, нярвын тайлан тооцоонд тусгаагүй нь УСНББОУС 1, 12, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.4.1, 13.1 дэх заалт болон аудитын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн үр дүнгийн тайлан (СТ-3А)-д залруулга хийлгэлээ.
- ✓ Бараа материалын дансанд 15,410.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинжийг агуулсан хөрөнгийг бүртгэсэн нь УСНББОУС 1, 12, 17, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.4.1, 13.1 дэх заалт болон аудитын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул бараа материалын тайланд залруулга хийлгэлээ.
- ✓ Нягтлан бодох бүртгэл хөтлөхдөө 1,179,054.6 мянган төгрөгийн гүйлгээг аккруэл суурийн дагуу өглөг болон зарлагаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй нь УСНББОУС 1, Төсвийн тухай хуулийн 26.1, 26.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1 дэх заалт болон аудитын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн үр дүнгийн тайлан (СТ-3А)-д залруулга хийлгэлээ.

Аудитаар нийт **47,847.2** мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 11,732.3 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 36,114.9 мянган төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 7 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 45,611.4 мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн 25,210.3 мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1 Цалингийн давтан тооцооллоор албан хаагчдад 4,010.3 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.**

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1.2 Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 7,722.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэлгүй бараа материал бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

## **5.2 Албан шаардлага**

5.2.1 Цалингийн сангаас албан хаагчдад 16,018.9 мянган төгрөгийн шагнал олгож төсвийн зориулалт бус зарцуулсан байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 190 дүгээр тушаалын 210104 "Төрийн албаны тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн дагуу ажлын үр дүнг сар, улирал, жилээр үнэлэн олгох мөнгөн урамшуулал ...гэх мэт зардлыг энд бүртгэнэ. Урамшуулал нь ажлын үзүүлэлтээр тооцож хагас бүтэн жилээр цалингийн тодорхой хувиар болон үнэмлэхүй хэмжээгээр тооцон олгох хэлбэртэй байж болно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

5.2.2 Төсөвт зохицуулалт хийлгүйгээр 17,860.2 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, зардлыг зориулалт бусаар зарцуулсан.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний 190 дүгээр тушаал, 2018 оны 6 дугаар сарын 8-ний өдрийн 134 дүгээр тушаалын 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

5.2.3 Тавилга эд хогшил дансанд 5 нэр төрлийн 10 ширхэг 2,235.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг буруу ангилан бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 271 дүгээр тогтоол "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.3. "Энэ журмын 4.1.1-д заасан хөрөнгийг хүлээн авч буй хуулийн этгээд тухайн иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрлийг албан ёсоор авч үндсэн болон эргэлтийн хөрөнгөөр нь ангилан, ашиглах хугацаа, чанар байдлыг нь харгалзан ашигласан хугацааны элэгдэл, хорогдлын шимтгэлийг тооцож данс бүртгэлдээ тусгана" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

5.2.4 Тус байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөл эд хөрөнгийн хариуцлагын гэрээг албан хаагчидтай байгуулаагүй бөгөөд хөрөнгийн хадгалалт хамгаалалтад тавих хяналт сул байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 86 дугаар тогтоолын хавсралт "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.1-д "Өмч хамгаалах зөвлөл нь төрийн өмчийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эд хөрөнгийн

эзэмшилт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, ашиглалтад хяналт тавих, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллана" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

5.2.5 Тус байгууллага нь дотоод хяналтын нэгжгүй, тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-д “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эрдэнэбулган сумын ЗДТГ	4	1256971.5	1	31606.3	3	1225365.2	4	1256971.5	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Эрдэнэбулган сумын ЗДТГ	7	47847.2	2	11732.3	5	36114.9	-	-	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
-	-	-	-	-	-	-	-	-	-	-